

## Агуулга

1.1 Төслийн нэр.....	3
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл.....	3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ .....	4
2.1 Төслийн талбайн байршил.....	4
2.2 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн төлөв байдал.....	5
2.8 Нийгэм эдийн засаг.....	9
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ .....	11
Агаарын чанар:.....	11
БҮЛЭГ 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	18
БҮЛЭГ 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	28
БҮЛЭГ 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	28
БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	28
БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	29
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..	32
БҮЛЭГ 12. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....	35
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ...	36
БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	42
БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЯНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ.....	45

## Зураг

Зураг 1 Төслийн талбайн сансарын зураг .....	3
Зураг 2 Төслийн талбайн байрзүйн зураг .....	4
Зураг 3 Газрын гадаргын өндөржилт.....	5
Зураг 4 Төслийн талбайн налуужилт .....	6
Зураг 5 Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураг .....	7
Зураг 6 Төслийн талбайн ургамлын хэв шинжийн зураг.....	8
Зураг 7 Нөлөөллийн эрчмийн зураг .....	11

“НЬЮ ФЛЮОРИТ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“БИЛГЭХ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Зураг 8	Техникийн үзлэг хийж буй зураг .....	19
Зураг 9	Уурхайн замыг тэмдэгжүүлэн зам зассан зураг .....	20
Зураг 10	Уурхайн нийт ажилчдад усны тухай сургалт орж буй зураг .....	21
Зураг 11	Усны гэрээ хийсэн болон шинжилгээний хариуны зураг .....	22
Зураг 12	Төслийн талбай дээр шаардлаггүй газар ухаагүй зураг .....	23
Зураг 13	Хог хаягдлын гэрээ болон хог ангилан ялгах савны зураг .....	24
Зураг 14	Төслийн талбайг хашаалсан байдлын зураг .....	25
Зураг 15	Сургалтын зураг .....	26
Зураг 16	Тэмдэгжүүлсэн зураг .....	27
Зураг 17	Гал унтраах багаж хэрэгслийн зураг .....	30
Зураг 18	Анхан шатны тусламжийн зураг .....	30
Зураг 19	Тайлангийн баталгаажсан зураг .....	30
Зураг 20	ХАБЭА-н сургалтын зураг .....	31
Зураг 21	Хог хаягдлын биелэлтийн зурагнууд .....	33
Зураг 22	Хог хаягдлын биелэлтийн зурагнууд .....	34
Зураг 23	Сумын хогийн цэгийн өмнө ба дараах зураг .....	35
Зураг 24	Усны гэрээ, төлбөрийн баримт , ус ашиглах дүгнэлт .....	37
Зураг 25	Усны гэрээ, төлбөрийн баримт , ус ашиглах дүгнэлт .....	38
Зураг 26	Тоосны шинжилгээний хариу .....	39
Зураг 27	Агаарын шинжилгээ .....	40
Зураг 28	Хөрсний шинжилгээ .....	41
Зураг 29	Галын хор байрлуулсан зураг .....	43
Зураг 30	Өдөр тутмын зааварчилгааны дэвтэр .....	43
Зураг 31	Ажилчдын хувцас хэрэгслээр хангаж буй зураг .....	44
Зураг 32	Байгаль орчин хамгаалах сургалт зохион байгуулж буй зураг .....	44
Зураг 33	Анхан шатны тусламжийн хэрэгсэл .....	44

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

“Билгэх-II” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төсөл.

**Төслийн зорилго:** “Билгэх-II” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглаж эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.

### 1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Нью флюорит” ХХК
Төслийн нэр	“Билгэх-II” хайлуур жоншны орыг ил аргаар ашиглах төсөл
Улсын бүртгэлийн дугаар	9011018054
Регистрийн дугаар	5076307
Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-015234
Хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 1-р хороо Их хуралдай бизнес төв 908 тоот
Утас	77112428



Зураг 1 Төслийн талбайн сансарын зураг


**БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-  
 ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

**2.1 Төслийн талбайн байршил**

Билгэх-II орд нь Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутгийн баруун урд хэсэгт, Улаанбаатар хотоос урд зүгт 278 км, Дундговь аймгийн төв Мандалговиос зүүн урд зүгт 57 км-т оршино.

Хүснэгт 2 Төслийн талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг
1	106° 50' 41.45"	45° 23' 48.56"
2	106° 50' 3.45"	45° 23' 48.56"
3	106° 50' 3.45"	47° 24' 9.56"
4	106° 50' 41.45"	47° 24' 9.56"




Зураг 2 Төслийн талбайн байрзүйн зураг

## 2.2 Төсөл хэрэгжих талбайн өнөөгийн төлөв байдал


“Нью флюорит” ХХК нь Ашигт Малтмал Газрын Тосны Газраас 2009 оны 11 сарын 02-ний өдөр MV-015234 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Билгэх-II” нэртэй хайлуур жоншны ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаанд олгосон. Төслийн талбайд өнөөгийн байдлаар ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна.

**Төсөл хэрэгжих талбайн газрын гадарга:** Монгол орны физик газарзүйн мужлалаар хээр ба говийн их мужийн шилжилтийн заагаар орших агаад цав толгодлог, ухаа гүвээт гэсэн хоёр төрлийн рельеф зонхилдог. Цав толгодлог рельефийн үнэмлэхүй өндөр нь баруун хойноосоо зүүн урагшлах тутам аажим намсаж 1214,6-1481,2 м-ийн хооронд хэлбэлзэх ба ихэвчлэн бөмбөгөрдүү орой, налуу хажуутай байдаг. Дээр дурьдсан тухайн нутгийн ноёлох өндөрлөгөөс гадна Лог-уул, Өндөр зараа толгой зэрэг сөнөсөн галт уул нь харьцангуй эгц хажуутай байна. Ухаа гүвээт талархаг рельеф нь цэрд, юрын хурдас тархсан Янзагын тал, Төгрөгийн ухаа, Яшилын хоолой зэрэг 1,152.2-1,369.8 м өргөгдсөн нутгуудад зонхилон тархжээ. Харьцангуй өндөр нь 10-30 м байдаг. Ийм төрлийн рельеф нь гуу жалгаар харьцангуй бага хэрчигдсэн байдаг.



Зураг 3 Газрын гадаргын өндөржилт

**Төсөл хэрэгжих газрын гадаргын налуу:** Гадаргын налуужилтын зураглалыг ArcGIS 10.8 программд зураглахад 0-6<sup>o</sup>C градуссын налуужилттай байна.




Зураг 4 Төслийн талбайн налуужилт

**Уул зүй:** Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөр, Дэлгэрхангай уул юм. Мөн Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Нутгийн хойд хэсэгт дээд палеозойн хурдас, өмнөд хэсгээр нь цэрдийн ба кайнозойн хурдас тархжээ. Дундговь аймгийн нутагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй. Тогоогийн, Дүүрэн Харганын, Олгой нуурын зэрэг рашаан бий.


**Уур амьсгал:** Тус бүсийн нутаг дэвсгэрийг уур амьсгалын хувьд хуурай, сэрүүн, уулын хээрийн муж (Эрдэнэдалайн хойд хэсэг, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэнгийн хойд хэсэг), нэн хуурай дулаавтар, цөлөрхөг хээрийн муж (/Дэлгэрхангай, Хулд, Луус, Гурвансайхан, Өндөршил сумын хойд хэсэг, Сайхан-Овоо, Сайнцагаан, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын нутаг), нэн хуурай дулаан, цөлөрхөг хээрийн муж (Дэлгэрхангай, Хулд, Гурвансайхан сумдын урд хэсэг, Өлзийт сумын нутаг) гэж 3 хуваадаг. Агаарын температурын дундаж хэмжээ өвлийн сард – 16-19 хэм, зуны сард +17-21 хэм, жилд орох хур тундасны хэмжээ 95-150 мм.

**Төслийн талбайн хөрс:** Жинхэнэ цөлийн хөрс манай орны урд хэсгээр тархаж улсын бүх нутгийн 9.3%-тай тэнцэх талбайг эзэлнэ. Түүний 6.9% нь хөндий хотгор, тал газраар, үлдсэн 2.4% нь уул толгодоор тархана. Сөөг, сөөгөнцөр, бутлаг ургамал зонхилсон цөлийн ургамалшил маш сийрэг тархай байдалтай, газрын гадаргын дөнгөж 5-10%-ийг бүрхэнэ. Ус чийг туйлын хомс, жилд дунджаар 50-90 см хур тунадас унахаас гадна өвөл хүйтэн, улирлын хөлдөлт 4 сар гаруй хугацаагаар үргэлжилдэг учраас хөрсөн дэх биологийн үйл явц маш боогдмол байна. Хөрсний хөлдөлтийн гүн өвөл 1-1.5 м хүрэх бөгөөд -10<sup>0</sup>C-ын температур хөрсөнд 25-30 см гүн нэвтэрдэг. Зуны хур борооны үед хөрсний дээд нимгэн үе чийглэгдэхэд биологийн үйл явц эрчимтэй явагдах нөхцөл бүрдэх авч түүний үргэлжлэх хугацаа даанч богинохон байна. Хур бороогүй гантай жил ургамлын ургалт хөгжилт зогсоход хүрдэг. Зарим жил ердийнхөөс их хур бороо ороход нэг наст ургамал газар сайгүй цэцэглэн цөл нутгийн ландшафт танигдахааргүй шахам сэргэдэг.Төсөл хэрэгжих талбайн хөрсний хэв шинжийг ArcGIS 10.8 программд зураглахад төслийн талбайн нам уулс, ухаа-толгодын хөрсний хэв шинжид хамаарах ба цайвар хүрэн хөрс тархсан байна.



Зураг 5 Төслийн талбайн хөрсний хэв шинжийн зураг

**Ургамал:** Тус бүс нь ургамлын бүрхэвчээр сийрэг, тачир ургамалтай. Төслийн талбайд түгээмэл тохиолдох ургамлууд: Нохой шээрэнг *Zygorhyllum xanthoxylon*, монгол буйлс *Amygdalus mongolica*, сибирь хармаг *Nitraria sibirica*, гялгар дэрс *Achnatherum splendens*, ширэг улалж *Carex druscula*, шарилж буюу шаваг *Artemesia* монгол азар *Calligonum mongolicum*, улаан бударгана *Reuamuria soongorica*, бор бударгана *Salsola passerina*, ахар навчит баглуур *Anabasis brevifolia*, хулан хойрго *Potaninia mongolica*, хөмүүл *Allium mongolica*, төв азийн лавай *Asterothamnus centralasiaticus*, Монгол өвс *Stipa gobica* зэрэг ургамлууд төслийн талбайд тархахдаа уул толгод, тал хөндий, гуу жалга, булаг шанд зэрэг газрын гадрага ургах орчноосоо хамаараад өөр өөр бүлгэмдэл бүлэг эвшил үүсгэх боловч ерөнхийдөө нохой шээрэнг *Zygorhyllum xanthoxylon*, Монгол өвс *Stipa gobica*, монгол буйлс *Amygdalus mongolica*, сибирь хармаг *Nitraria sibirica*, гялгар дэрс *Achnatherum splendens*, ширэг улалж *Carex druscula*, шарилж буюу шаваг *Artemesia* зэрэг ургамлууд холилдон ургаж бүлгэмдэл бүлэг эвшил үүсгэж байна. Төсөл хэрэгжих талбайн хөрсний хэв шинжийг ArcGIS 10.8 программд зураглахад тус талбайд тэгш тал газрын цөлийн хээрийн хэв шинжийн алтан гаргана оролцсон хялганат ургамал тархсан байна.



Зураг 6 Төслийн талбайн ургамлын хэв шинжийн зураг

**Амьтны аймаг:** Энэ район нь Аргаль, янгир, чоно, үнэг, хярс, мануул, хар сүүлт, цагаан зээр зэрэг ан амьтан, хур, сойр, ятуу, ногтруу, ангир, тогоруу, хулан жороо, талын бүргэд, тас, идлэг шонхор зэрэг жигүүртэн, алагдаахай, оготно, хүрэн, бозлог зэрэг мэрэгчид амьдардаг.

**Хүн ам, дэд бүтэц:** 1924 онд Гучин сум нэртэй байсныг Гурвансайхан сум болгон нэрийг нь өөрчилж Цагаан хошууны Гучин жасын суурин дээр анх байгуулагдсан. 1952 онд тус газраас нүүн одоогийн байгаа Чингийн Суугантад суурьшсан байна. Гурвансайхан сум нь байршлын хувьд аймгийн төвөөс зүүн урагш 71 км, Улаанбаатар хотоос 300 кмт оршдог. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 541.647 га нутаг дэвсгэртэй, говийн бүсэд багтдаг, сумын хамгийн хойд талын цэг Баянзүрх уул, урд цэг Хэрээ шарга овоо, Зайрмагтайн худаг, зүүн захын цэг Хамар цагаан жаргалан уул, баруун захын цэг Хөөврийн худаг хүрдэг. Өөрийн аймгийн Өлзийт, Өндөршил, Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Сайнцагаан сумуудтай нутгийн хил залгадаг. Сумын нутаг дэвсгэр нь ихэнхдээ жижиг ухаа толгод зонхилох Их газрын чулуу, Гурвансайхан, Уул хадаргантай, Чин, Суудал уул зэрэг үзэсгэлэнт газруудтай. 2003 га газрыг улсын тусгай хамгаалалтын газрын дурсгалт газрын ангилалд бүртгэн авсан. Мөн тус сум нь монгол улсын жишиг сум юм.

**Хүн ам:** Гурвансайхан сум нь нийт таван багт хуваадаг бөгөөд одоогийн байдлаар тухайн багт бүртгэлтэй нийт хүн амын тоог доор харуулав.

- ❖ Элгэн баг- 389
- ❖ Дэрсэнэ-Ус баг-507
- ❖ Чулуут баг-488
- ❖ Гурвансайхан баг-408
- ❖ Суугаант баг-355

## **2.8 Нийгэм эдийн засаг**

Төсөл хэрэгжих Гурвансайхан суманд ашигт малтмалын Салхитын мөнгөний орд, Цагаан тээгийн гантиг, Лог үнстийн нүүрс, Гурвансайхан ураны баялаг ордуудтай цаашид хайгуул хийж нөөцийг нь тогтоохоор олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл 9 байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл 17 байна.

**Зам тээвэр:** Дундговь аймгийн Гурвансайхан сум нь аймгийн төвөөс зүүн урагш 71 км, Улаанбаатар хотоос 300 км-т оршдог. Аймгийн төвөөс сум хүртэл шороон замаар холбогддог байна.


**Ус хангамж:** Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худагтай. Энэ худаг нь сумын төвийн иргэдийн ундны усыг хангадаг. Энэ 2 худгийн ус нь шохойн чулуулгийн улмаас тунадас их хэмжээгээр үүсдэг бөгөөд шүүлтүүр тавьж цэвэршүүлэх шаардлагатай. Бэлчээрийн усан хангамжийн хувьд ерөмдлөгийн 26 худаг байна.

**Эрүүл мэндийн төв:** Сумын төв 1939 онд Цагаан хошуунд Гучин хийдийн төв дээр шилжиж суурьшснаар эмнэлгийн үйлчилгээ тогтмолжсон гэж үздэг. Сум 1952 онд Суугаантад төвлөрснөөс эхэлж амбултори, больниц, төрөх тасаг гэсэн 3 гэртэй эмчилгээ, үйлчилгээг явуулж байсан ба 1964 онд анх эмнэлгийн 4 өрөө байртай болж, 1968 онд хүний их эмчийн салбар болон өргөжиж, их эмч-1, бага эмч, сувилагч 6 хүний бүрэлдхүүнтэйгээр ажиллаж байжээ. Одоо Сумын эрүүл мэндийн төв нь 16 ажиллагсадтай 2 их эмч, 1 эхбаригч, 1 бага эмч, 1 НЭМА, 4 сувилагч, 2 үйлчлэгч, лаборант, нярав, нягтлан жолооч, тогоочийн орон тоотойгоор сумын 2168 хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

**Хот байгуулалт газрын харилцаа:** Гурвансайхан сумын төв нь Засаг захиргаа, үйлчилгээний үүрэг давамгайлсан сум юм. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2007 онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр боловсруулсан. Сумын төвийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн өнөөгийн байдал: ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс 9.2 га хөдөө аж ахуйн бүс 514.900га өнөөгийн байдлаар 156 өрхөд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 11.52 га газар өмчилж, 345 өрхөд өвөлжөө, хаваржааны зориулалтаар 253 га газар, 3 аж ахуй нэгж амралт, аялал жуулчлалын зориулалтаар 4.2 га газар эзэмшиж байна.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Ньюфлюорит” ХХК-ны Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Билгэх-II” нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр тухайн бүс тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь хүнд даацын машины хөдөлгөөн, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үеийн тоос тоосонцор, дуу чимээ зэрэг юм.



Зураг 7 Нөлөөллийн эрчмийн зураг

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

#### Агаарын чанар:

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

### **Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**

- ✓ Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- ✓ Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- ✓ Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- ✓ Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- ✓ Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- ✚ Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- ✚ Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- ✚ Олон салаа зам гарган зорчих
- ✚ Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- ✚ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- ✚ Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

### **Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ**

- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- ✓ Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- ✓ Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- ✓ Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрт ачуулах, ангилан ялгаж байх
- ✓ Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- ✓ Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

**Гадаргын болон газрын доорх ус:** “Билгэх-II” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн гидрогеологийн судалгаагаар уурхайн ашиглалтын талбайд гүний уст цэг илрээгүй байна. Мөн унд ахуйн усны хэрэгцээг хангахын тулд шинэ худаг гаргахаар төлөвлөсөн. Төслийн талбайн ойр орчимд гол горхи, булаг шанд

зэрэг гадаргын усны эх үүсвэр байхгүй байна. Иймд төсөл хэрэгжих явцад байгалийн усны нөөц болон усны бохирдолд үзүүлэх нөлөөлөл байхгүй юм. Гэвч ахуйн бохир ус болон хог хаягдлыг зөв байршуулаагүй мөн орчны цэвэрлэгээ хийгээгүйн улмаас гадаргын болон хөрсний усыг тодорхой хэмжээгээр бохирдуулж болзошгүй.

***Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:***

- ✓ “Ньюфлюорит” ХХК нь цэвэрлэх байгууламж байгуулан шингэн хаягдлыг байгаль орчинд халгүй арга хэлбэрээр зайлуулах, дахин ашиглах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн 2019 оны 05 сарын 02нд батлагдсан нэмэлт өөрчлөлтийг, Усны тухай хуулийн 3.1.32, 3.1.33, 25, MNS 4943:2015 стандарт, 2.2-2.4, 25 дугаар зүйлийн 25.1, 8 дугаар зүйл, зэргийг дагаж мөрдөнө ажиллахыг зөвлөж байна.

**Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:** Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

***Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:***

- ✓ Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- ✓ Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- ✓ Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- ✓ Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

**Ургамлан нөмрөг:** Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй.

***Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:***

- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- ✓ Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- ✓ Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- ✓ Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

**Амьтны аймаг:** Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тыархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

***Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ:***

- ✓ Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- ✓ Ховор амьтадыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- ✓ Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- ✓ Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

**Нийгэм эдийн засаг:** Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална. Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

Аливаа төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход

**“НЬЮ ФЛЮОРИТ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“БИЛГЭХ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруудах замаар хэрэгждэг. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байна, байхгүй гэсэн зарчмаар үнэлэх бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ уг үнэлгээнд оролцсон шинжээч, судлаачдын дүгнэлтийг үндэслэн 2 төрлийн жагсаалт гаргасан. Нөлөөллийн хэлбэр нь үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь “шууд”, “шууд бус”, “буцаж нөлөөлөх”, “буцалтгүй нөлөөлөх”, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд “богино хугацааны”, “урт хугацааны”, эрчмийн хувьд “бага зэрэг”, “дунд”, “хүчтэй” гэхчилэн ангилсан магадлах жагсаах аргаар тодорхойлсон. Доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зураг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
<b>Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл</b>											
1	Газрын доорх усны чанар		x		x			x	x		
2	Газрын доорх усны нөөц		x			x		x	x		
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x	x		x		
4	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x								
<b>Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
5	Усны чанар, хэмжээ		x		x		x			x	
6	Агаарын бохирдол		x		x			x	x		
7	Хөрсний бохирдол		x			x	x		x		
8	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		x		x			x		x	
9	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x							x		
<b>Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>											
10	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	
11	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх										
12	Хүн, амын орлого нэмэгдэх	+				+		+		+	
13	Хүн амын тоо өөрчлөгдөх										

**“НЬЮ ФЛЮОРИТ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“БИЛГЭХ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Эдийн засаг, байгаль орчин												
14	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+		+		+		+		
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+				+
16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+			
17	Ажлын байр нэмэгдэх	+				+	+				+	
18	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+			
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x				x	
Бусад нөлөөлөл												
20	Хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих		x		x		x		x			
21	Нөлөөллийн тоо ширхэг	Сөрөг	2	9		6	3	5	4	7	3	
		Эерэг	6	1	1	1	6	2	5	2	4	1

Тайлбар: “+” эерэг, “x” сөрөг

Хүснэгт 4 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал

Шууд нөлөөллийн тоо: 8	
Эерэг нөлөөлөл нь: 6	Сөрөг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх</li> <li>- Хүн, амын орлого нэмэгдэх</li> <li>- Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх</li> <li>- Орон нутгийн орлого нэмэгдэх</li> <li>- Ажлын байр нэмэгдэх</li> <li>- Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөрсний элэгдэл, эвдрэл</li> <li>- Дуу чимээ, шуугианы нөлөө</li> </ul>
Шууд бус нөлөөллийн тоо: 5	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь: 4
<ul style="list-style-type: none"> <li>- Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын доорх усны чанар</li> <li>- Усны чанар, хэмжээ</li> <li>- Агаарын бохирдол</li> <li>- Хөрсний бохирдол</li> </ul>
Өөрөө зохицуулагдах нөлөөллийн тоо: 1	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь:
<ul style="list-style-type: none"> <li>- Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх</li> </ul>	
Богино хугацааны нөлөөллийн тоо: 3	
Сөрөг нөлөөлөл нь: 2	Эерэг нөлөөлөл нь: 1
<ul style="list-style-type: none"> <li>- Усны чанар, хэмжээ</li> <li>- Агаарын бохирдол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх</li> </ul>

**“НЬЮ ФЛЮОРИТ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“БИЛГЭХ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧИН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

<b>Урт хугацааны нөлөөллийн тоо : 9</b>	
<b>Сөрөг нөлөөлөл нь: 3</b>	<b>Эерэг нөлөөлөл нь: 6</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Газрын доорх усны чанар</li> <li>- Хөрсний элэгдэл, эвдрэл</li> <li>- Хөрсний бохирдол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх</li> <li>- Хүн, амын орлого нэмэгдэх</li> <li>- Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх</li> <li>- Орон нутгийн орлого нэмэгдэх</li> <li>- Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох</li> <li>- Ажлын байр нэмэгдэх</li> </ul>
<b>Буцах нөлөөллийн тоо: 4</b>	
<b>Сөрөг нөлөөлөл нь: 2</b>	<b>Эерэг нөлөөлөл нь: 2</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Хөрсний элэгдэл, эвдрэл</li> <li>- Усны чанар, хэмжээ</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ажлын байр нэмэгдэх</li> <li>- Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх</li> </ul>
<b>Буцалтгүй нөлөөллийн тоо: 9</b>	
<b>Сөрөг нөлөөлөл нь: 4</b>	<b>Эерэг нөлөөлөл нь: 5</b>
<ul style="list-style-type: none"> <li>- Газрын доорх усны чанар</li> <li>- Газрын доорх усны нөөц</li> <li>- Агаарын бохирдол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх</li> <li>- Хүн, амын орлого нэмэгдэх</li> <li>- Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх</li> <li>- Орон нутгийн орлого нэмэгдэх</li> <li>- Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох</li> </ul>
<b>Сулавтар нөлөөллийн тоо: 9</b>	
<b>Сөрөг нөлөөлөл нь: 7</b>	<b>Эерэг нөлөөлөл нь: 2</b>
<b>Эрчимтэй нөлөөллийн тоо : 1</b>	
<b>Сөрөг нөлөөлөл нь: 0</b>	<b>Эерэг нөлөөлөл нь: 1</b>
	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутгийн орлого нэмэгдэх</li> </ul>

**БҮЛЭГ 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх хувь	Тайлбар
1	Машин тоног төхөөрөмжөөс гарах утааг хянах тогтмол үзлэг хийх	Уурхайн ашиглалтын талбайд	100	Уурхайн ажилчид ээлж солигдох бүрд машин механизмын бүрэн бүтэн байдлыг шалган хүлээлцэн ямар нэгэн эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд арга хэмжээ авдаг.
2	Олон салаа зам гаргахгүй байхад анхаарал хяналт тавих	Уурхайн бүх ажилчдад	100	Уурхай дотор болон гадаа тээвэрлэлтэд нэг маршрутын зам гарган олон салаа зам гаргахгүй байхад анхааран ажиллаж байна.
3	Ажилчидад усыг ариг гамтай хэрэглэх, хамгаалах тухай сургалт зохион байгуулах	Уурхайн нийт ажилчдад	100	Уурхайн нийт ажилчдад “Цэнхэр алт” усны тухай сургалт орсон ба шинэ ажилчид нэмэгдэх бүр усны тухай мэдлэг өгдөг.
4	Ажилчдын унд ахуйн усанд ашиглаж байгаа гүний худгаас дээж авч шинжилгээ хийлгэх	Гүний худаг	100	Аймгийн УЦУОШ төвтэй гэрээ байгуулан хамран ажиллаж байна.
5	Үйл ажилгааны явцад үссэн нүх шуудууг бөглөх	Төслийн талбайд	100	Шаардлагагүй газарт нүх шуудуу гараагүй болно
6	Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байршуулах	Төслийн талбайд	100	Ангилан ялгах хогийн цэг байгуулан сум орон нутагтай гэрээ байгуулан ачилт хийлгэж байна.
7	Төслийн талбайг тойруулан хашаалах	Төслийн хүрээнд	100	Мал болон хүн унаж бэртэхээс хамгаалан төслийн талбайг тойруулан хашаалсан.
8	Төслийн үйл ажиллагааны үед ашигласан тос, тослох материалыг ил задгай хаяхгүй байх сургалт зохион байгуулах	Уурхайн нийт ажилчдад	100	Нийт ажилчдад аюултай хог хаягдал бол хор аюулын зэрэглэл тэдгээрийг ангилан ялгах сургалт зохион байгуулсан
9	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах тэмдэг тавих	Уурхайн хүрээнд	100	Төслийн талбайд нэвтрэх болон ойртох үеийн хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлан тэмдэгжүүлсэн

**“НЬО ФЛЮОРИТ” ХХК-ИЙН ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “БИЛГЭХ-II” ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

"Нью флюорит" ХХК Билгэх 2 хайлуур жоншны уурхай			
Машин механизм ажиллуулахаас өмнөх шалгах хуудас			
Операторын нэр ТОНОГ ТӨХӨӨРӨЙ Экскаватор		Огноо: 2025.10.26 ТЛ-ийн дугаар: ТКОБ	
Ээлж эхлэх үеийн мото/цагийн заалт		Ээлж дуусах үеийн мото/цагийн заалт	
<b>A. Тойрох үзлэг</b>	OK	Зогсолдог гарын үсэг	Тайлбар дүгнэлт
- Тос, ус, тулш гоожилтыг шалгах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Хүрээний тосны дүрэм
- Гинжийн нөхцөл байдлыг шалгах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Хүрээний тосны дүрэм
- Гинжийн чанга суулыг шалгах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- Алваа гэмтлийг шалгах & тэмдэглэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- Шанага болон шүднүүдийг шалгах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- Нүүрс, шороо дарж шавьдсан эсэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- Машины ойр хүн, техник байгаа эсэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- 3 цагээр хүрэлцэх дүрмээр машинд орох	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
<b>B. Кабины үзлэг</b>	OK	Зогсолдог гарын үсэг	Тайлбар дүгнэлт
- Мастер унтраалгыг асаах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Кабины үзлэг
- Зогсоолын тормос татах	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- Суудал тохируулах, суудлын бүс зүүх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Шанаа цэвэрлэх
- Шанагыг газар буулгана	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Тайлбар дүгнэлт
- Арааг нейтрал байрлалд шилжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
- Газартай харьцах эд ангийн удирдлагын хөшүүргийг ХВВӨХ байрлалд шилжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	
